Хичээл зүтгэл ба хувь тохиол

(Монголын Анагаах Ухааны хөгжилд профессор Ч.Цэрэннадмидийн гүйцэтгэсэн үүрэг)

Ц.Одгэрэл[1], Ц. Энхжаргал[2], Ц. Лхагвасүрэн[3,4]

[1]АШУҮИС, АУС, Цус судлалын тэнхим, [2]Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
[3]АШУҮИС, 4Монголын Анагаах Ухааны Академи

ТОЙМ ӨГҮҮЛЭЛ

Түлхүүр үг:

Эрүүлийг хамгаалах
Эрүүл мэнд
Дотрын анагаах ухаан
Цус судлал
Эмч
Багш
Эрдэмтэн судлаач

Товч утга: Монгол Улсын ардын эмч, Эрүүлийг хамгаалахын гавъяат ажилтан, МАУА-ийг санаачлан үүсгэн байгуулагчдын нэг профессор Чойжилжавын Цэрэннадмид бол Монголын уудам хөдөө нутагт эмнэлгийн анхан шатны тусламжийг бага, дунд мэргэжлийн түвшингээс дээд боловсролтой, их эмчийн түвшинд шилжүүлэх, аймгийн төвүүд дэх эмнэлгүүдийг үндсэн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үзүүлдэг болгон шинэ шатанд гаргах зэрэг эрүүл мэндийн салбарын нэн чухал хөгжлийн эхлэлийг тавилцаж, манай орны эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэхэд их үүрэг гүйцэтгэсэн түүхэн гавьяатан, Монголын эрүүл мэндийн салбарын бүх шатны байгуулагад, эмнэлзүй, эрдэм шинжилгээ, сургалт, судалгаа, эрүүл мэндийн удирдлага зохион байгуулалт гээд анагаахын шинжлэх ухааны бүхийл чиглэлд амжилттай ажиллаж байсан чадварлаг эмч, багш, сурган хүмүүжүүлэгч, эрдэмтэн, зохион байгуулагч, төр нийгмийн зүтгэлтэн мөн. Монголын анагаах ухаан, эрүүл мэндийн салбарын хөгжилд профессор Ч.Цэрэннадмидын гүйцэтгэсэн үүрэг, хийж бүтээснийг хойч үед таниулан мөнхжүүлэх зорилгоор “Монголын анагаахын мэргэд” цувралын XXX ботийг түүний мэндэлсэний 90 насны ойн босгон дээр ийнхүү тоймлон хүргэж байна.

Профессор Ч.Цэрэннадмид бол төр нийгмийн зүтгэлтэн, эрүүлийг хамгаалахын чадварлаг зохион байгуулагч мөн:

1955 онд Ч.Цэрэннадмидыг МУИС-ийн Хүн эмнэлгийн факультетийг төгсөх жил түүнд төрөлх сургуульдаа багшаар ажиллах, мөн тэр үед дөнгөж байгуулагдаад байсан Сүрьеэгийн больницын ерөнхий эмч, эсвэл Ховд аймгийн Эмнэлгийн хэлтсийн даргаар ажиллах санал ирсэнч өөрийн итгэл үнэмшилдээ хөтлөгдсөн залуу эмч маань эх орныхоо алслагдсан суманд ажилъя гэж өөрийн хүсэлтээр Баянхонгор аймгийн Баянлиг сумаас хөдөлмөрийн гараагаа эхэлсэн байдаг. Дэлхийн II дайн дуусаад удаагүй, улс орны хөгжил дөнгөж тогтворжиж эхэлж байгаа, нийт хүн амын эрүүл мэндийн байдал яггүй бэрхшээлтэй, өвчлөл, нас баралт, ялангуяа сүрьеэ, тэмбүү зэрэг халдварт өвчний тархалт нилээд өндөр, төрөлт, дундаж наслалт их доогуур байсан тэр л он жилүүдэд говийн бөглүү суманд “Соёлын үр”-ийг тарьж эмч, орос хэлний багш, орчуулагч, зөвлөгч, номын санч, улаан булангийн ухуулагч гээд хөдөөгийн ардыг соён гэгээрүүлэх, эмчлэн эдгэрүүлэх их үйлсэд бүхий л чадлаараа шамдан зүтгэв.

Сумын их эмчийн анхны салбаруудын нэгийг байгуулав:

Монголынхоо уудам нутгийн хөдөөд эмнэлгийн анхан шатны тусламжийг бага, дунд мэргэжлийн түвшинд үзүүлж байсныг дээд боловсролтой, их эмчийн түвшинд шилжүүлэх, аймгийн төвүүд дэх эмнэлгүүдэд үндсэн нарийн мэргэжлийн тусламж үзүүлдэг болгон шинэ шатанд гаргах эрүүл мэндийн салбарын нэн чухал хөгжлийн эхлэлийг тавихад эмч Ч.Цэрэннадмид идэвхтэй оролцжээ. Баянхонгор аймгийн Богд суманд хожим сум дундын эмнэлэг болгохоор зохион байгуулж, ажиллуулж байсан эмнэлгийг эмч Ч.Цэрэннадмид Баянлиг суманд шинээр баригдсан 13 өрөө бүхий барилгад нүүлгэн, их эмчийн салбарыг зохион байгуулж, тэр хавийн Богд, Жинст, Баянговь, Баян-Өндөр, Баянлиг 5 суманд эмнэлгийн тусламжийг их эмчийн түвшинд үзүүлдэг болж, сумандаа анхны мэс заслыг хийж, арьс өнгөний болон сүрьеэг илрүүлэх үзлэг, хүн амаа үзлэг шинжилгээнд идэвхтэй хамруулж, өвчлөлийг илрүүлэх, өвчтөнийг эмчлэн эдгэрүүлэх, харьяа сумдад дуудлагаар очиж үзлэг хийж зөвлөгөө өгөх, эмнэлгийн ажилчиддаа хичээл зааж, мэргэжлийг нь дээшлүүлэх, эмийн сангаа өргөтгөж, шаардлагатай эмийг хүрэлцээтэй болгох, шинэ салбараа аж ахуйн хувьд бэхжүүлэхэд мужаан, ногоочинтой хамтран ажиллах гээд бүхий л ажлыг үлгэрлэн зохион байгуулж байв. Дээрх сумдууд аймгаасаа нилээд алслагдсаны дээр газар нутаг нь өргөн, хүн ам нь тархуу байрладгийг

аймгийн удирдлагууд анхаарч их эмчийн салбарыг анх байгуулж, үйлчилгээг хурдан шуурхай болгоход түргэн тусламжийн машин нэн хэрэгтэй гэсэн Ч.Цэрэннадмид эмчийн саналыг дэмжиж, дээд байгууллагууд, ЭХЯ-нд хүсэлт тавьснаар, Баянлиг сумын их эмчийн салбар Монголдоо анх удаа эмнэлгийн автомашинтай болсон нь хөдөөгийн хөдөлмөрчдөд эмнэлгийн түргэн тусламжийг цаг алдалгүй хүргэх, харьяа сумын эмнэлгүүддээ ойр ойрхон очиж зөвлөгөө өгч ажилд нь туслахад ихээхэн дөхөм болсон байдаг. Иймхүү сумын их эмчийн анхны салбаруудын нэгийг байгуулж, түүнийгээ бүх талаар бэхжүүлэхийн төлөө идэвх чармайлттай ажиллаж байсныг нь аймаг, орон нутгийн удирдлага, ЭХЯ, МАХН-ын Төв Хороо өндөр үнэлж байсны нэг нотолгоо бол түүнийг ажиллаад жил гаруйхан болж байхад нь 1959 онд Япон улсад зохиогдох Олон улсын хуралд оролцуулах төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд оруулан явуулж байсан явдал юм.

Аймгийн төвийн эмнэлгийг өргөтгөн зохион байгуулав:

Түүнийг Баянлиг сумын эмнэлэгт 2 жил гаруй эрчимтэй ажиллаж байхад нь Баянхонгор аймгийн төвийн эмнэлгийн мэс заслын эмч, хожим Гавьяат эмч болсон Б.Хас гачигдлын улмаас Улаанбаатар руу шилжих болсон тул Ч.Цэрэннадмид эмчийг говиос татаж, аймгийн төвд мэс засалчаар ажиллуулах болжээ.Тэрээр Баянхонгор аймгийн төвийн эмнэлгийн мэс засалчаар төдийгүй, мөн дотор, эмэгтэйчүүдийн тасгийг давхар хариуцан ажиллахын зэрэгцээ ерөнхий эмчийг хавсран гүйцэтгэхдээ, эмнэлгийнхээ эмчилгээ үйлчилгээг сайжруулахын төлөө чармайн зүтгэж, уг эмнэлэгт тэр үед рентген шинжилгээ хийдэггүй байсан тул рентген аппарат хөөцөлдөн олж авах, лабораторийн шинжилгээг өргөтгөн чанаржуулах, амбулаторийг анх удаа байгуулах зэрэг ажлыг эмч нартайгаа хамтран зохион байгуулсан байна.

Улсын төв эмнэлгийн дотрын тасгийн эрхлэгч:

ЭХЯ-ны сайдын 1957 оны 8-р сарын 29-ний 143-аар тушалаар Ч.Цэрэннадмид эмч Улсын төв больнцын дотрын 2-р тасгийн эрхлэгчээр томилогдож ажилласан түүхтэй. “Эрдэмтэн эмч, сайд Чойжилжавын Цэрэннадмид багштан” хэмээх Монголын анагаахын мэргэд цувралын XXX ботийг тэрлэхээр судалгааны материал цуглуулж,, уншиж, танилцах явцад УНТЭ-ийн түүхэнд холбогдох эх сурвалжуудад эмч Ч.Цэрэннадмид нь төв больницын дотрын 2-р тасгийн эрхлэгчээр ажиллаж байсан тухай мэдээлэл огт дурдагдаагүй тул энэ талаар бодит мэдээлэлийг өгөх үүднээс нэмэлт тайлбар өгөх нь зүйтэй болов уу. Ч.Цэрэннадмид тасгийнхаа эмчилгээ, үйлчилгээг сургалттай хослон явуулж, эмчилгээ-оношилгоог сайжруулах ажлыг тэнхимийн эрхлэгч-зөвлөгч профессор И.И.Крыжановскаягийн удирдлага доор идэвхтэй зохион байгуулж, оношилгоо-эмчилгээний хэд хэдэн шинэ аргуудыг тасгийнхаа үйл ажиллагаанд нэвтрүүлсний дээр, Улаанбаатар хот, хөдөө орон нутагт зөвлөгөө өгч ажилладаг байв.

1950-1960 онд манай орны жирэмсэн, хөхүүл эхчүүдийн дунд элбэг тохиолдож, олон эх, хүүхдийн амь насанд хүрч байсан, тэр үед манай эмч нар учир шалтгааныг нь мэдэхгүй, эмчилж сайн чадахгүй байсан цус багадах хүнд өвчтэй эмэгтэйчүүд Ч.Цэрэннадмидын эрхэлж байсан тасагт хот, хөдөөнөөс, ялангуяа говийн аймгуудаас олноор ирж хэвтдэг байсан тул профессор И.И.Крыжановская ийм өвчинтэй тааралдаж байгаагүй бөгөөд орон нутгийн өвөрмөц өвчин байж болох тул ном, хэвлэлтэй сайн танилцаж, нарийн учрыг нь олохыг эмч Ч.Цэрэннадмидад зөвлөж байсан нь ёстой л “хувь тохиол” гэгчээр хожим докторын судалгааны сэдэв болж, манай эмэгтэйчүүд, хүүхдүүдийн дунд газар аваад байсан цус багадалтын хүнд эмгэгийн оношилгоо эмчилгээний асуудлыг бүрэн шийдвэрлэсэн төдийгүй, Цус судлалын албыг Монголд Улсдаа үндэслэн байгуулж, энэ салбарыг олон улсын түвшинд хүртэл хөгжихөд үлгэрлэн манлайлж, удирдан зохион байгуулсан.

Тусгай эмнэлгийн хамгийн удаан ажилласан дарга:

Ч.Цэрэннадмидыг 1964 онд ЗХУ-д аспирантур төгсөөд ирэхэд нь МАХН-ын ТХ-ноос түүнийг СнЗ-ийн Хэрэг эрхлэх газрын харьяа Тусгай эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч даргаар томилж, удалгүй ерөнхий эмчээр томилон ажиллуулжээ (1964-1973). Энэ эмнэлгийн удирдлагаар ажиллах хугацаандаа тэрээр тусгай эмнэлгийн төдийгүй Монгол Улсын, ялангуяа төрөлжсөн нарийн мэргэжилийн эмнэлгүүдийн хөгжлийг хэд хэдэн шатаар урагшлуулсан явдал юм.Тусгай эмнэлэгт түүнийг ажиллах 10 жилд уг эмнэлгийн материаллаг бааз бэхжиж, боловсон хүчин нь чадавхжиж, эмч нарын тоо, түргэн тусламж-үйлчилгээний машины тоо тус бүр 2-3 дахин нэмэгдэж, Дархан хотод салбараа нээсэн томоохон эмнэлэг болтлоо өргөжиж, эмчилгээ-үйлчилгээний чанар, хэмжээ, хүрээ өсөн нэмэгдэж, хатуу сахилга бат, дэг журамтай, улс орондоо цуутай хөдөлмөрийн чадварлаг хамт олон бүрэлдэн тогтож чаджээ.

Төр нийгмийн зүтгэлтэн –Эрүүлийг хамгаалахын сайд:

МАХН-ын ТХ-ны Улс төрийн товчооны 1986 оны 01-р сарын 27-ны өдрийн 19-р тогтоолоор профессор Ч.Цэрэннадмид Эрүүлийг Хамгаалах Яамны сайдаар томилогдож, 4 жил гаруй хугацаанд ажиллахдаа эмч, мэргэжилтний ажиллах орчин, мэдлэг мэргэжлийг нь сайжруулах, тэдний ахуй амьдрал, цалин хөлсийг нэмэгдүүлэх зэрэг ажилд онцгой анхаарч, хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалж бэхжүүлэх ажилд улс, хоршоолол, олон нийтийн байгууллага, хамт олон, хувь хүний оролцоо, хариуцлага анхаарлыг төвлөрүүлэх, ялангуяа урьдчилан сэргийлэх ажил, амбулатори-поликлиникийн үйл ажиллагааг давамгайлан хөгжүүлэх, эх нялхас, хөдөөгийн хүн ардын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах, халдварт өвчнийг бууруулах зэрэг үйлсэд хүч бололцоогоо дайчлан ажилласны дүнд эрүүл мэндийн салбарын боловсон хүчний хангамж сайжирч, ялангуяа нарийн мэргэжлийн тусламжийн хүрээ, тоо чанар өргөжин хөгжиж, эрүүл мэндийн салбарын материаллаг баазад бодитой ахиц гарч, эрүүлийг хамгаалах салбарын

хүрэлцээ хангамж тоон үзүүлэлтээр дэлхийн улс орнуудын дундаж түвшинд хүрсэн байна.

Профессор Ч.Цэрэннадмид ЭХЯ-ыг толгойлон ажиллах хугацаанд эмнэлгийн 160 гаруй том жижиг барилга баригдсаны дотор Улаанбаатар хотноо III клиникийн төв эмнэлэг, Эх нялхсын эрдэм шинжилгээний төв, Халдварт болон Хавдар судлалын төвүүд, хэд хэдэн аймаг, Шарын гол, Бэрхийн уурхай, Дархан хот зэрэгт нэгдсэн эмнэлэгүүд, төрөх газруудын томоохон барилгууд шинээр баригдан ашиглалтанд орж, эхосонограф, фиброэндоскоп, компьютерт томограф, ангиограф, лазерын аппарат, электрон микроскоп, барокамер, гемосорбц, компьютерийн хяналт зэрэг орчин үеийн өндөр хүчин чадалтай оношилгоо, эмчилгээ, шинжилгээний аппарат, багаж төхөөрөмж суурилагдан, оношилгооны эмчилгээний шинэ аргууд эмнэлзүйн практикт нэвтэрч эхэлжээ .

Тэрээр эрүүлийг хамгаалахын боловсон хүчинг чадавхжуулахад анхаарч, өөрийн орны боломж болон олон улсын байгууллагуудын тусламжийг нэмэгдүүлэх замаар жил бүр аспирантурт 5-7, ординатурт 15-20, төрөлжсөн нарийн мэргэжлийн сургалтанд 75-200 хүнийг анагаах ухааны өндөр хөгжилтэй гадаадын улс орнуудад байнга суралцуулдаг болсноор нарийн мэргэжлийн өндөр мэдлэгтэй хүмүүс бэлтгэгдэж, эх нялхас, халдварт өвчин, хавдар судлалын төв зэрэг анагаах ухаан, сургалт,судалгаа практикийн нэгдмэл томоохон төвүүдийг бий болгосон ба АУДС, эрдэм шинжилгээний байгууллагуудын нарийн мэргэжлийн багш, судлаачдын хүрэлцээ хангамжийг сайжруулснаар нарийн мэргэжлийн тусламж хөгжих боломжийг бүрдүүлж эхэлсэн байна.

1987-1990 онуудад бүх аймаг, хотын эмнэлгүүдийг хэт авиа, фибро-эндоскопийн шинжилгээний аппараттай болгож, тэдгээрийг эзэмшин ажиллуулах мэргэжилтнүүдийг нь бэлтгэсэн төдийгүй ардын эмнэлэг, бариа, зүү, заслыг хөгжүүлэх зорилгоор Хятад, Өвөр Монгол, Вьетнам, Энэтхэг, Солонгос, Япон зэрэг орноос мэргэжилтэн урин ирүүлж үндэсний болон олон улсын чанартай курс, семинарийг зохион байгуулж, мөн тэдгээр оронд эмч, мэргэжилтэн, оюутан явуулж сургах зэрэг олон талын арга хэмжээг авч ажиллажээ.

Сумдыг нүүдлийн амбулатори, лабораторийн үйлчилгээтэй болгох, сум бүрийг 2-оос дээш их эмч, түргэн тусламжийн машинтай болгох арга хэмжээ авч, нийт аймаг сумын төвд төрөхийн өмнөх эхчүүдийн байр байгуулах, сум дундын эмнэлгийг өргөтгөх зэрэг арга хэмжээ авсан нь зохих үр дүнгээ өгсөн байна.

Эмч, эмнэлгийн ажилчдын цалинг тэр үеийн ханшаар нилээд нэмэгдүүлж, ажлын үр дүн, хортой, хүнд нөхцлийн нэмэгдлийг олгох хүрээг өргөтгөсөн ба төсөвт аж ахуйн тооцоонд шилжүүлэх, дамжлага чирэгдлийг багасгах зэрэг олон ажлуудыг зохион байгуулсан юм.

Гадаад харилцааны талаар ихээхэн анхаарч, ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Үйлдвэр хөгжлийн сан, НҮБ-ын Хүн амын сан зэрэг олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг идэвхижүүлж, тэдгээрийн захирал, удирдах хүмүүсийг өөрийн орондоо урьж, холбоо харилцааг тогтоож, хамтын ажиллагааны хөтөлбөр боловсруулах зэргээр олон улсын байгууллагаас авах тусламжийн хэмжээг мэдэгдэхүйц нэмэгдүүлж, ДОХ-ын үндэсний төв лаборатори байгуулж, уг өвчинтэй тэмцэх 3 шатны хөтөлбөрийг ДЭМБ-ын тусламжаар хэрэгжүүлж эхэлжээ.

Япон улсаас эмнэлгийн багаж төхөөрөмжийн тусламж авах, нэг удаагийн тариур, вируст гепатитын эсрэг вакцин үйлдвэрлэх төслийн тухай хэлэлцүүлгийг боловсруулан шийдвэрлүүлэх ажлыг эхлүүлсэн ба эх нялхасын эрүүл мэндийг сайжруулах зэрэг 2000 он хүртэл хэрэгжих 5 цогцолбор хөтөлбөрийг боловсруулж, холбогдох газраар батлуулан хэрэгжүүлж эхэлсэн байна.

Анагаахын боловсрол судлалд профессор Ч.Цэрэннадмидын оруулсан хувь нэмэр, түүний сургалтын арга барилын онцлог:

1957 онд ЭХЯ-ны тухайн үеийн сайд асан Туваан гуай зөвлөх Карандашевын хамт арьс өнгөний бригадыг эргэж яваад Баянлиг суманд очжээ. Тэр үед үнэндээ хөдөө байтугай хотод байгаа эмч нар ашиглах монгол сурах бичиг, монгол эмнэлгийн ном ховор, ер нь байхгүй байсан. Тэд эмч Ч.Цэрэннадмид Зөвлөлтийн "Бага эмч", "Сувилагчийн ажил" зэрэг сэтгүүл, сурахуудаас орчуулж, сумынхаа эмнэлгийн ажилчдад хичээл зааж байгаатай таарсан ба тэрээр Зөвлөлтийн хүн эмнэлгийн техникумын гол сурах бичгүүдийг орчуулж, хэвлэмээр байгаа тухай саналаа сайдад танилцуулжээ. Дараа жил нь сайдын тушаал гарч, хүн эмнэлгийн техникумын сурах бичиг орчуулах ЭХЯ-ны 1-р орлогч сайд Д.Цагаанхүүгээр ахлуулсан 7 хүний бүрэлдхүүнтэй комисст сумын эмч Ч.Цэрэннадмидыг урин оруулжээ. Түүнд А.Л.Капланы “Эх барихуйн ухаан” гэдэг 35.5 хэвлэлийн хуудас, нилээд зузаан номыг орчуулах үүрэг ногдсон байв. Тэр үед өрнийн анагаах ухааны ямарч ном монгол хэлээр гараагүй, нэр томъёо ч боловсроогүй байсан тул Ч.Цэрэннадмид эмчид номын сангуудаар хуучин ном, судар хайх, хүмүүсээс асууж зөвлөх, тэр ч байтугай их эрдэмтэн Б.Ринчен гуай дээр очиж зөвлөгөө авах ч хэрэг гарч байв. Орчуулгын энэ багийнхны анх нэвтрүүлсэн анагаахын олон нэр томъёо одоо хүртэл Монголын анагаах ухаанд өргөн хэрэглэгдсээр байна. Профессор Ч.Цэрэннадмид ажиллах хугацаандаа мэргэжлийн сурах бичиг, гарын авлага, ном товхимол 23-ыг зохион бичиж, 4 номыг орос, англи хэлнээс орчуулж хэвлүүлсэн ба өөрийн шавь, багш, нэртэй эрдэмтэн судлаачдын бичсэн 54 ном, сурах бичиг, гарын авлагыг редакторлож хэвлүүлсэн байна.

Профессор Ч.Цэрэннадмидын удирдаж байсан тэнхим дээр Дотор өвчний судалгаа, Сүрьеэ судлал, Рентген оношилгоо, Физик эмчилгээ, Эмчилгээний биеийн тамир зэрэг хичээлүүд заагддаг байсан ба тэдгээр хичээл заадаг багш нарыг бэлтгэж, мэргэжлийг нь дээшлүүлэх, хичээлийн хөтөлбөр, заах арга, техник хэрэгслийн хангамжийг сайжруулах зэрэгт анхаарч АУДС-ийн хичээлийн хөтөлбөрийг хэд хэдэн удаа шинэчлэхэд, ялангуяа 5 жилийн сургалтаас 6 жилийн сургалтанд шилжих хөтөлбөрт Дотрын өвчний хичээлийн хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн

ахлагчаар ажиллаж байжээ.

Профессор Ч.Цэрэннадмид багш МУИС, АУДС, АУИС, ЭМШУИС-д иар суралцан төгссөн 13000 гаруй эмч, эрүүл мэндийн ажилтнууд, мөн нарийн мэргэжил эзэмших болон мэргэжлийн курсээр давтан бэлтгэгдсэн 1000 гаруй эмч мэргэжилтнийг сурган бэлтгэж, мэдлэг мэргэжлээ залуу үеийнхэнд өвлүүлэн сургаж иржээ. Түүний үр дүнд багшийн бэлтгэж өгсөн шавь нар нь одоо Ч.Цэрэннадмид багшийнхаа орон зайг, түүний зааж сургасан эрдэм ухаанаар нь дүүргэн, дотрын өвчин судлал, цусны эмгэг судлалыг эрч хүчтэй хөгжүүлэн, хүн ардынхаа эрүүл мэндийн төлөө улам олуулаа, улам эрч хүчтэй зүтгэцгээж байгна.

Профессор Ч.Цэрэннадмид бол анагаахын эрдэмтэн багш, нэрт сурган хүмүүжүүлэгч мөн:

Их сургуулийн багш байна гэдэг бол нарийн мэргэжлдээ тун сайн мэргэшсэн хүний хийдэг ажил. Ялангуяа анагаах ухааны их сургуулийн багш байна гэдэг нь анагаах ухааны тодорхой мэргэжлээр мэргэшсэн сайн эмч төдийгүй, сайн судлаач, сурган хүмүүжүүлэгч байх учиртай. Профессор Ч.Цэрэннадмид багш дээрх бүх чанарын бүрдэл болсон нэгэн байсан ба эрүүл мэнд, шинжлэх ухаан, боловсролын салбарт 57 жил эмч, багш, судлаачаар ажиллахдаа эмч, эмнэлгийн мэргэжилтэн сургаж бэлтгэхэд өөрийн амьдралын 49 жилийг зарцуулсан цусны эмгэг судлалын манай анхны монгол мэргэжилтэн, нэртэй клиницист, арвин туршлагатай чадваралаг багш нарын нэг байсан юм.

Тэрээр оюутан ахуй үеэсээ багшилж эхэлжээ. МУИС-ийн Хүн эмнэлгийн факультетэд онц сурдаг байсан тул 5-р курст сурч байх үеэсээ Хүн эмнэлгийн техникумд цагаар багшилж, курсын бага эмч, сувилагч нарт эмийн эмчилгээний хичээлийг заадаг байжээ. Эмч болсон хойноо хөдөөгийн сум, аймгийнхаа эмнэлгийн дунд мэргэжилтнүүдэд мэргэжлийн хичээл заадаг байсан ба аспирантурт сурч байхдаа судалгааныхаа дагуу лекц, дадлагын хичээлийг Москвагийн их сургуулийн оюутнуудад, мөн курсийн эмч, аспирант нарт заавал заах үүргийн дагуу курс бүрт мегалобластын цус багадалтаар 2 цагийн лекц уншиж, 4 цагийн дадлага тогтмол удирддаг байжээ. II тусгай эмнэлэгт ажиллаж байхдаа ч эмнэлгийн зохион байгуулалт, оношилгоо эмчилгээ, эмнэлзүйн тэр их ачааллын хажуугаар анагаахын сургуулийн 3, 4-р дамжааны оюутнуудад Дотрын онош зүйн хичээл заадаг байсан болно. Ч.Цэрэннадмид эмч 1973 оноос Дотрын өвчин судлалын тэнхимийн эрхлэгчээр ажилласнаас хойш тэнхим, клиникийн эрхлэгч, АУДС-ийн эрдэм шинжилгээ, гадаад харилцаа эрхэлсэн проректор, цус судлалын салбарын профессор багш зэргээр МУИС-ийн ХЭ-ийн факультет, АУДС, АУИС, ЭМШУИС-иудад 2012 оныг хүртэл төгсөлтийн өмнөх болон дараах мэргэжүүлэх, мэргэшүүлэх бүх шатны сургалтанд тасралтгүй багшилсан юм. Тэрээр сургалтын бүхийл түвшинд өвчтөний дэргэдэх эмнэлзүйн сургалт, асуудалд суурилсан сургалтыг жинхэнэ утгаар нь явуулж, суралцагчдын эмнэлзүйн сэтгэлгээг хөгжүүлэх, сурах идэвхийг өрнүүлэх, эмнэлгийн орчинд ажил хэрэгч, зарчимч байдал, шударга ёсыг төлөвшүүлэхээс эхлээд мэдлэг мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх, нотолгоонд суурилсан оношлогоо, эмчилгээ, сургалт, судалгааны хамтарсан үйл ажиллагаа гээд олон зүйлийг амьд ажил болгоход цаг хайргүй зүтгэж, биеэ чилээж явсан. Профессор Ч.Цэрэннадмид сургалтанд дараах зарчмуудыг нягт баримталдаг байсан. Үүнд:

- Сургалтын процессыг эрүүлийг хамгаалахын практик амьдралтай нягт холбож, ойртуулах, оюутан залуучууд, суралцагчдын мэргэжил, мэдлэгийн түвшин, эх оронч хүмүүжил, эмчийн ёс зүйд илүүтэй анхаарах
- Мэргэжлийн боловсон хүчин, ялангуяа эмч, эмнэлгийн боловсон хүчинд эрхэм дээд нинжин сэтгэл, эх оронч хүмүүжлийн дээр насан турш тасралтгүй сурч, өөрийгөө боловсруулах чанар хамгийн чухал гэдгийг ойлгуулах
- Эмнэлгийн шинэ боловсон хүчнийг хүлээж авч байгаа байгууллага, хамт олноос тэр шинэ соёолж буй үрийг цааш яаж үржүүлэн бойжуулж, хэн болгох вэ гэдэг нь хамаарах тул ихэд анхаарч, сайн хүн болгох, цаашид өсч, мэргэжих, зөв хүн болгоход нь хайр халамж, анхаарал тавих, ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх
- "Тасралтгүй сургах" сургалтын системийг сургууль, практикийн байгууллагын хамтын нэгдсэн хүчээр тууштай хэрэгжүүлж, оюутан, эмчийг сургах, сэлбэн мэргэшүүлэх ажлыг боловсронгуй болгох

Үнэндээ профессор Ч.Цэрэннадмид багш бол манай Монгол Улсад дотрын анагаах ухаан, тэр тусмаа цусны эмгэг судлалаар мэргэшсэн ховор хүн. Түүний нягт нямбай, асуудлыг үндэс сууринаас нь авч үздэг чанар, аливаа асуудалд шат харгалзахгүйгээр ханддаг байх зарчим, аливаад ёс зүй, журамтай байх, ажилд эзний ёсоор ханддаг байх гэхчилэн мундаг зан чанарыг мөрдлөг болгон ажилладаг нь залуучуудад үлгэрд ууриал болдог байлаа. Тийм учраас Ч.Цэрэннадмид багшаар хичээл заалгуулах нь тухайн үедээ оюутан залуучуудад амар хялбар зүйл огт биш бөгөөд түүний шаардлагад нийцэн сурч, ажиллах нь өөрөөсөө ихээхэн хүч хөдөлмөрийг шаарддаг байсан талтай. Харин хожмоо хэн боловч багшийн тэр арвин даалгавар, өндөр шаарлага нь мөн ч их ач тустай байсныг өгүүлж баярлаж байх нь олонтой.

Анагаахын шинжлэх ухааны нэрт эрдэмтэн, судлаач:

Профессор Ч.Цэрэннадмид багшийн эрхлэн гүйцэтгэж байсан ажлуудыг аваад үзэхэд эрдэм шинжилгээ, судалгаатай холбоотой ажлуудад илүү ойр явж ирсэн нь түүний эрдэмлэг, аливаад нотолгоотой ханддаг зан чанарын илрэл хэмээн харагддаг. Тэр ч чанараараа их сургуулийн эрдэм шинжилгээ эрхэлсэн проректор гэдэг хариуцлатай албанд профессор Ч.Цэрэннадмид багшийг үр бүтээлтэй, санаачлага дүүрэн ажиллаж чадсан хэмээн үздэг.

Тэрээр, тухайн үед манай эрүүлийг хамгаалах салбарт шийдвэрлэх шаардлагатай байсан асуудлуудыг хөндсөн чухал шийдэл, зөвлөмж, дүгнэлтүүдийг тусгасан 90 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл, аргачилсан зөвлөмж бичсэнээс 21 нь гадаадын

хэвлэлд нийтлэгдэж, 100 гаруй эрдэм шинжилгээний илтгэл тавьж хэлэлцүүлснээс нилээд нь (16) гадаадын мэргэжлийн сэтгүүл, эмхэтгэлд хэвлэгдсэн ба 10 гаруй оронд зохиогдсон олон улсын чуулган, их хурлуудад Монгол орноо төлөөлөн илтгэл хэлэлцүүлэн идэвхтэй оролцож, эрдэм шинжилгээний 8 төсөлт ажлын удирдагч болон зөвлөхөөр ажиллаж байжээ. Тэрээр Америкийн цээжний эмч нарын холбооны гишүүнээр сонгогдож, Японы Лабораторийн болон эмнэлзүйн эмгэг судлаачдын нийгэмлэгийн хүндэт гишүүний өргөмжлөлийг хүртэж байсан удаатай.

Профессор Ч.Цэрэннадмид АУДС-ийн Эрдэм шинжилгээ, гадаад харилцаа эрхэлсэн проректороор ажиллаж байхдаа Эрдэм шинжилгээний Төв лаборатори байгуулсан нь багш, аспирантуудын судалгааны ажилд их дөхөм болсон ба багш нарыг ЗХУ болон бусад гадаад оронд аспирантур, докторантурт суралцуулах, Зөвлөлтийн эрдэмтдийг шаардлагатай сэдвээр, шаардлагатай тэнхим дээр урьж ажиллуулан, тэднийг багш нарын эрдэм шинжилгээний ажилд туслуулах ажлыг тодорхой төлөвлөгөөтэйгөөр тогтмол зохиодог болгож, багш нарын эрдэм шинжилгээний хурлыг жил бүр зохион явуудаг болгон тогтмолжуулж, судалгааны материалуудыг нь эмхэтгэн, өөрөө редакторлаж гаргадаг болжээ.

Профессор Ч.Цэрэннадмид ЭХЯ-ны эрдмийн зөвлөлийн дүрмийг анх боловсруулж, батлуулан, тус зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, Анагаах ухаанаар эрдмийн зэрэг, цол олгох зөвлөлийн гишүүнээр 30 гаруй жил ажилласан ба Монголын ШУА-ын бага чуулганы гишүүн, Анагаах ухааны Академийн үндэслэгч гишүүн, ЭМШУИС-ийн эрдмийн зөвлөлийн тэргүүлэгч гишүүн, Эрдмийн зэрэг, цол хамгаалуулах зөвлөлийн гишүүн, мөн I, II, III клиникийн эмнэлгүүд, анагаах ухааны хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн гишүүнээр тус тус ажиллаж байжээ.

Тэрээр АУИС-ийн эрдэм шинжилгээний үндсэн чиглэлийг боловсруулж, түүнийг олон талаас нь иж бүрнээр судлахын тулд аль болохоор хам судалгааг өргөжүүлэн бэхжүүлж, багш, оюутан, лабораторийн хүчийг төвлөрүүлэн, өргөн хамруулах, эрдэм шинжилгээний ажлын төлөвлөлтийг боловсронгуй болгох, шийдвэрлэх комиссын ажилтай нягт уялдуулж, хүн бүрийн судалгааны ажлын сэдэв, аргачлалыг тодорхой хугацаатайгаар улирал, жилээр төлөвлөн, тэнхим, шийдвэрлэх комиссоор нягт нямбай хэлэлцсэний дараагаар факультет, сургуулийн эрдмийн зөвлөлөөр батлуулж, явцыг батлагдсан хугацаатай нь холбож, улирал, хагас, бүтэн жилээр нарийн хянан дүгнэж байхын дээр эрдэм шинжилгээний ажлыг төлөвлөхдөө түүнээс практик ач холбогдлыг нарийн бодон тооцоолж, зохих төлөвлөсөн хугацаанд нь заавал нэвтрүүлж, үр ашиг, өгөөжийг нь тодорхой тооцоолон дүгнэж байх журмыг тууштай нэвтрүүлэн хэвшүүлэх, жил бүрийн эрдэм шинжилгээний тайланг гаргахдаа төлөвлөгөөг хэрхэн биелүүлсэнтэй нарийвчлан тооцоолж дүгнэхийн дээр практикт нэвтрүүлсэн ажлыг үр дүнгээр нь нарийн гаргаж, дараа жилд нэвтрүүлэх ажлыг тодорхой үндэстэй төлөвлөн, тэнхим, факультетээр хэлэлцэн баталж, сургуулийн захиргаанд ирүүлж байхыг журамлаж, сургууль, факультетийн эрдмийн зөвлөл, тэнхимийн эрхлэгчдийн хариуцлагыг өндөржүүлж, уг зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн дарга нар, ЭШСТЛ-ийн эрхлэгч, тэнхимийн эрхлэгч нарын бие дааж, ажлаа бүрэн хариуцдаг болгоход анхааран ажилласан байна. Түүний удирдлагаар 2 хүн Анагаахын шинжлэх ухааны доктор, 8 хүн Анагаах ухааны доктор, 17 хүн магистрын зэрэг хамгаалж, мөн 40 гаруй эмч дотрын эмчийн I, II зэрэг авч, ахлах болон тэргүүлэх, зөвлөх эмчийн зэргийг амжилттай хамгаалсан байна

Дотрын анагаах ухааны монголын тэргүүлэх мэргэжилтэн, зөвлөх эмч:

Монгол улсад дотрын өвчин судлал, түүн дотроо цус судлалын шинжлэх ухааныг цогцлоон хөгжүүлэх хүндэт үүрэг эрүүл мэндийн түүхэн хөгжлийн явцад түүнд ноогдсон юм. Түүнийг Дотрын Цэрэннадмид, Цусны Цэрэннадмид багш гэдгээр нь Монголд мэдэхгүй хүн байхгүй гэж хэлэхэд нэг их хилсдэхгүй болов уу.

ЭХЯ-ны сайдын тушаалаар Төв больницын Дотрын тасгийн эрхлэгчээр томилсон тэр үеэс залуу эмч эмчилгээ-оношилгоог сайжруулах ажлыг тэнхимийн эрхлэгч-зөвлөгч профессор И.И.Крыжановскаягийн удирдлага доор идэвхтэй зохион байгуулж, оношлогоо-эмчилгээний хэд хэдэн шинэ аргуудыг тасгийнхаа ажиллагаанд нэвтрүүлсэн байдаг. Одоогийн Клиникийн III эмнэлгийн үндэс нь болсон Мэс заслын эмнэлэг, мөн Цэргийн госпиталь, Дотоод Яамны эмнэлэг, Сайд нарын эмнэлэг, Сэтгэл мэдрэлийн, Сүрьеэгийн эмнэлгүүдэд профессор И.И.Крыжановскаягийн зөвлөгөө өгөхөд хамт явж, дагалдан суралцаж, шаардлагатай үед орчуулга хийж, удалгүй Сэтгэл-мэдрэлийн эмнэлэг, Сүрьеэгийн эмнэлэгт эмч Ч.Цэрэннадмидыг биеэ даан дотрын зөвлөгөө өгч байхыг багш нь даалгасан тул тэдгээр эмнэлэгт дотор өвчний зөвлөхөөр давхар ажилладаг болжээ.

Ч.Цэрэннадмид эмч зөвхөн Улаанбаатар хотын эмнэлгүүдэд зөвлөгөө өгөх төдийгүй бас аймгуудад мэргэжлийн эмч дутмаг байсан учир дуудлагаар явж зөвлөгөө өгдөг байжээ. Профессор Ч.Цэрэннадмид улсын төв эмнэлэгүүдийн зөвлөх, Эрүүл мэндийн яамны дотрын ерөнхий зөвлөхөөр насан өндөр болтолоо тасралтгүй идэвхийлэн 50 гаруй жил үр бүтээлтэй ажиллахдаа олон мянган хүний оношлогоо, эмчилгээний асуудлыг шийдвэрлэх, ээдрээ, бэрхшээлтэй үед эмч-багш-шавь нартаа зөвлөн тусалсаар иржээ. Тэрээр нийгмийн хөжлийн ялгаатай үе шатуудад, анагаахын хуучин, шинэ концепцуудын давуу талуудыг өөрийн үйл ажиллагаандаа чадварлагаар ашиглаж чаддаг хамгийн удаан хугацаанд ажилласан, бүх нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, үлгэр дууриал болсон зөвлөх эмч-мэргэжилтэн-багш юм.

Эрүүл мэндийн салбарт тасралтгүй 57 жил ажиллах хугацаандаа профессор Ч.Цэрэннадмид Монголдоо урьд нь оношлогдож байгаагүй цусны болон дотрын 20 гаруй өвчнийг анх оношилж, тэдгээрийн оношилгоо, эмчилгээний аргыг эмч, шавь нартаа зааж сургасан байна. Профессор Ч.Цэрэннадмид манай орны эрүүлийг хамгаалах ажлыг сайжруулахад дотор өвчний

үед үзүүлэх эмнэлгийн тусламжийг боловсронгуй болгох явдал тэргүүн зэргийн ач холбогдолтой гэж үзэж, үүний тулд нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламж, дотрын эмчийн үзүүлэх тусламж хоёрыг зөв зохистойгоор хослон хөгжүүлэх ёстой гэсэн саналыг бүр 1980-аад онд дэвшүүлж байжээ. ЭМЯ-ны дотрын ерөнхий зөвлөхийн хувьд тулгарч байгаа асуудлыг урьдчилан олж харах, шийдвэрлэх бодитой санал бодлуудаа илэрхийлж байсны зарим нь өнөөдөр ч үнэ цэнээ алдаагүй байна.

Цусны эмгэг судлаач Монголын анхны мэргэжилтэн, эмч, эрдэмтэн:

Профессор Ч.Цэрэннадмид нь Монгол улсын эрүүл мэндийн тогтолцоонд цус судлалын салбарыг үүсгэн байгуулж, энэ салбарыг дэлхий нийтийн хөгжлийн түвшинд хүргэхэд ихээхэн хувь нэмэр оруулж, түүчээлж, шинжлэх ухаанчаар хөгжүүлсэн эрхэм мөн гэдэгтэй хэн ч маргахгүй. МУИС-ийн ректорын 1961 оны 1-р сарын 4-ний 351-р тушаалаар Ч.Цэрэннадмид ЗХУ-ын Москва хотноо эмч нарын мэргэжил дээшлүүлэх төв институтийн аспирантурт суралцан (1961-1964), цус судлалаар дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн нэрт эрдэмтэн профессор Е.А.Кост, Г.Г.Газенко, академич И.А.Кассирский нарын удирдлаган дор “О перниционоподобной анемии беремености и послеродового периода у женщин Монгольской Народной Республики” сэдвээр АУ-ны докторын зэрэг хамгаалжээ. Суралцах хугацаандаа тэрээр клиникийн цус судлалаар мэргэшиж, цусны нарийн шинжилгээнүүдийг бие даан хийж чаддаг болжээ.

Эх орондоо эргэн ирээд, профессор Ч.Цэрэннадмид В12 витамин, сийвэнгийн төмөр, цусны цитоморфологийн болон ясны чөмөгний цитологи, цитохимийн шинжилгээнүүдийг Монголдоо анх удаа хийж, нэвтрүүлснээр манай эмэгтэйчүүдэд тохиолдож байсан хүнд өвчний шалтгаан, эмгэг жамыг тогтоож, түүнийг эрт оношилж, эмчлэх, урьдчилан сэргийлэх аргыг нь боловсруулсны үр дүнд уг өвчнийг эрт оношилж, эмчлэн, сэргийлж чаддаг болсон тул тэрхүү өвчин буурч, түүгээр эмэгтэйчүүд нас барах нь эрс багассан байна. Профессор Ч.Цэрэннадмид манай эрүүлийг хамгаалахын салбарт цусны эмгэг судлаач анхны мэргэжилтэн эмч, эрдэмтэн болж, цусны эмгэг судлалыг Монголдоо үндэслэн, хөгжүүлж, эмч мэргэжилтнийг сурган бэлтгэх, цусны өвчний салбар, тэнхим, тасгийг байгуулах, хот хөдөөгийн эмнэлгүүдэд мэргэжлээрээ зөвлөгөө өгөх, эрдэм шинжилгээний судалгаа хийх ажлуудыг 54 жил сэтгэл зүрхээрээ бүтээлчээр гүйцэтгэсэн бөгөөд ЭМЯ-ны Цусны эмгэг судлалын ерөнхий мэргэжилтнээр олон жил ажилласан юм. Профессор Ч.Цэрэннадмидын 80 насныхаа босгон дээр буюу 2009 онд Монгол улсад “Цусны үүдэл эс шилжүүлэн суулгах” үндэсний хөтөлбөрийн хүрээнд ОУ-ын төслийг боловсруулж, амжилттай хэрэгжүүлсэний үр дүнд одоогоор аутолог үүдэл эсийг цусны болон цусны бус эмгэгийн нийт 20 гаруй тохиолдолд шилжүүлэн суулгаад байна.

Дотрын шинжлэх ухааны салбарын хөгжилд профессор Ч.Цэрэннадмидын гүйцэтгэсэн үүрэг:

1964 онд Ч.Цэрэннадмид эмчид үзүүлж зөвлөгөө авахаар хүнд өвчтэй хүн ирэхэд үжлийн үүсэлтэй бөөрний цочмог дутагдалтайг нь оношилж, тэр үед манай оронд хийгддэггүй, ЗХУ-д нэвтрээд удаагүй байсан гемодиализ (бөөр орлуулах) эмчилгээг хийлгэх шаардлагатай гэж шийдэж, уг өвчтөнийг Москва руу Ч.Цэрэннадмид эмч өөрөө яаралтай хүргэхээр авч явж, ЗХУ-д байгуулагдаад удаагүй байсан гемодиализын төвд эмчлүүлж аварсан нь Монголдоо анхных нь байжээ. Тэрээр уг төвийн үйл ажиллагаатай танилцаж ирээд Монголд гемодиализын төв байгуулах шаардлагатай тул ЗХУ-аас мэргэжилтэн урих, аппарат багаж авахад шаардагдах нэрс, марк, зардал зэргийн талаар ЭХЯ-ны сайдад санал тавьснаас хойш удалгүй манайд Гемодиализын төв байгуулахаар ЗХУ-аас мэргэжилтэн урих, манай эмч нараас гадаадад явуулж сургах, аппарат, тоног төхөөрөмжийг авах ажил хийгдэж эхэлсэн түүхтэй.

Профессор Ч.Цэрэннадмид 1985 онд Зөвлөлтийн ревматологичдын их хуралд оролцохдоо ЗХУ-ын Ревматологийн Төв Институтийн захирал, академич, профессор В.А.Насоноватай уулзаж, Монгоын байдлыг танилцуулаад, сайн ревматологич явуулах боломжийг эрэлхийлж санал тавьснаар тэр жилдээ Ярославль хотын Анагаах Ухааны Дээд Сургуулийн Дотор өвчин судлалын тэнхимийн эрхлэгч, Зөвлөлтийн ревматологичдын нийгэмлэгийн тэргүүлэгч гишүүн, нэртэй ревматологич, доктор, профессор В.Я.Бобылев Монголд ирж ажилласан байлаг. Ийнхүү Ч.Цэрэннадмид эмч Зөвлөлтийн эрдэмтэн, нэрт ревматологч, профессор В.Я.Бобылевтой 1960-1970 онуудад манайд тэр бүр өргөн оношлогддоггүй байсан коллагены өвчнүүд болон ревматизм, ревматоид артритаар хамтран судалгаа явуулж, ном, сурах бичиг, олон тооны өгүүлэл, илтгэл бичиж гадаад, дотоодын мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд хэвлүүлсэн ба уг чиглэлээр нэг хүний докторын зэргийг удирдан хамгаалуулжээ.

Ч.Цэрэннадмид багш ЭМЯ–ны сайд байхдаа 1986 онд улсын 3-р эмнэлэгт (хуучин нэрээр) Японы АЛОКА фирмийн 2D зүрхний ЭХО аппаратыг хуваарьла үр бүтээлтэй н, тус эмнэлгийн Онош зүйн төвд байрлуулсан нь БНМАУ-ын хэмжээнд зүрхний эмгэгийн оношилгоо -эмчилгээний асуудлыг шийдвэрлэхэд их хувь нэмэр болсон төдийгүй, энэ эмнэлэг зүрх судасны чиглэлээр хүн ардадаа тэргүүлэх үйлчилгээг үзүүлэхүндэс болсон гэдгийг Шастинчууд болон энэ эмнэлэгйн үе үеийн удирдлага, эмч нар ярьж тэмдэглэх дуртай билээ.

Эрүүл мэндийн салбарын хөгжилд профессор Ч.Цэрэннадмидын оруулсан хувь нэмрийг Монголын төр өндрөөр үнэлж алтан гадас одонгоор 2 удаа (1971.1981), Эрүүлийг хамгаалахын гавьат ажилтан (1999), Монгол Улсын ардын эмч (2005) цол олгожээ.Энэ бүхнийг нэгтгэн дүгнэвэл профессор Ч.Цэрэннадмид бол Монголын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг шинэ түвшинд гаргасан түүхэн гавьяатан, эмнэлзүй,

эрдэм шинжилгээ, сургалт, судалгаа, эрүүл мэндийн зохион байгуулалт гээд анагаахын шинжлэх ухааны бүхий л чиглэлд амжилттай ажиллаж чадсан олон эмч-багш, шавь нарынхаа бахархал, үлгэр дууриал болсон чадварлаг эмч-багш, сурган хүмүүжүүлэгч, эрдэмтэн, зохион байгуулагч эрхэм хүн мөн болно

Ном зүй:

1. *Профессор Ч.Цэрэннадмидын бичиж үлдээсэн гар бичмэл, санал, ажлын тайлангууд*
2. *П. Нямдаваа, Г. Дашзэвэг. Монгол улсын эрүүл мэндийн бодлогын түүхэн хөгжил, хэтийн төлөв. Монголын анагаах ухаан,1996, 1(94)*
3. *Ч.Цэрэннадмид. Тувaан сайд. Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүл. 2008, 4(23)*
4. *Ц. Лхагвасүрэн, Г. Батбаатар. Он цагийн түүхэн товчоо. 2017*
5. *Ц. Лхагвасүрэн, Ч.Энхжаргал, Ц.Одгэрэл "Эрдэмтэн эмч, сайд Чойжилжавын Цэрэннадмид багштан". Монголын анагаахын мэргэд цувралын XXX боть, 2018*